



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,

Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас/Факс: (976-51) 26 75 33,

Цахим шуудан: info@mojha.gov.mn,

Цахим хуудас: www.mojha.gov.mn

2024.10.16 № 11314
танай 2024.10.02 -ны № 01/2180 -т

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА Ч.ЧИМИДСҮРЭН ТАНАА

“Журам батлах тухай” Татварын ерөнхий газрын дарга, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2024 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн А/204,А/161 дүгээр хамтарсан тушаалыг захирагааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн 6959... дугаарт бүртгэснийг үүгээр хүргүүлж байна.



О.АЛТАНГЭРЭЛ

151603863
A5.файл.2024

Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн бүртгэлд
2024 оны 10. сарын 16-ны
өдрийн 6959 дугаарт бүртгэв.

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА,
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ХАМТАРСАН ТУШААЛ

2024 оны 09 дүгээр
сарын 16-ны өдөр

Дугаар A/204, A/162

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.2 дахь заалт, 8.4 дэх хэсэг, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Цэцэрлэг, ногоон байгууламж, авто зогсоолын шаардлага хангаагүй үл хөдлөх эд хөрөнгөд нэмэгдүүлсэн хувиар албан татвар ногдуулах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Татварын ерөнхий газрын Татвар төлөгчид үйлчлэх газар (Б.Буяннэмэх), Улсын бүртгэлийн ерөнхий газрын Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газар (Б.Ариунболд)-т тус тус даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Татварын ерөнхий газрын Төрийн захиргаа, удирдлагын газар (Л.Нэргүй), Улсын бүртгэлийн ерөнхий газрын Тамгын газар (Д.Давааням)-т тус тус үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Татварын ерөнхий газрын дарга, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн A/105, A/68 дугаар хамтарсан тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.


ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА

Ч.ЧИМИДСҮРЭН

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГА

Д.ДӨЛГЭРСАЙХАН
5296722 1118266215

Бүртгэлийн дугаар 293
ТАТВАРЫН ЕРӨНХИЙ
ГАЗАР
ХУУЛБАР УЧИН
Хуулбар олгосын ажилтны гарын усаг
2024 оны 10. сарын 01-ний өдөр
ks



Цэцэрлэг, ногоон байгууламж, авто зогсоолын шаардлага хангаагүй
үл хөдлөх эд хөрөнгөд нэмэгдүүлсэн хувиар
албан татвар ногдуулах журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмын зорилго нь Эрхийн улсын бүртгэлд бүртгэгдсэн "Хот байгуулалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.6.3, 12.8-д заасан цэцэрлэг, ногоон байгууламж, авто зогсоолын шаардлага хангаагүй" /цаашид "шаардлага хангаагүй" гэх/ үл хөдлөх эд хөрөнгөд Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т заасан хувиар албан татвар нэмэгдүүлэн ногдуулах харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Цэцэрлэг, ногоон байгууламж, авто зогсоолын шаардлага хангаагүй үл хөдлөх эд хөрөнгийг тодорхойлох, бүртгэх


2.1. Аймаг, нийслэл, улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын Хот байгуулалт, барилгын стандартын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь нутаг дэвсгэртээ байрших "шаардлага хангаагүй" үл хөдлөх эд хөрөнгийн мэдээллийг боловсруулж, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.3-д заасан мэдээллийн санд бүртгэнэ.

2.2. Хот байгуулалт, барилгын стандартын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь үл хөдлөх хөрөнгийн шаардлага хангасан болон "шаардлага хангаагүй" эсэхийг тодорхойлж, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 9 дүгээр зүйлийн 9.11-д заасан дундын мэдээллийн санд тухай бүр цахим хэлбэрээр дамжуулна.

2.3. Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь энэ журмын 2.2-т заасан үл хөдлөх эд хөрөнгийн мэдээллийг хүлээн авч холбогдох бусад мэдээлэлтэй тулган нягталж, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн системд ялгарах байдлаар бүртгэнэ.

2.4. Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь энэ журмын 2.3 дахь хэсэгт заасан мэдээллийг Татварын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1, 34.8.2-т заасны дагуу төрийн мэдээлэл солилцооны "ХУР" системээр дамжуулан тухай бүр татварын албанад хүргүүлнэ.

2.5. Татварын алба "шаардлага хангаагүй" үл хөдлөх эд хөрөнгийг бүртгэх, бүртгэлийн мэдээллийг өөрчлөхөд Татварын болон Улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргын хамтран баталсан "Татвар төлөгчийн бүртгэлийн журам"-ыг баримтлан Татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгэнэ.



**Гурав. Албан татварыг нэмэгдүүлэн
ногдуулах, чөлөөлөх, төлөх**

3.1. Эрхийн улсын бүртгэлд бүртгэгдсэн "шаардлага хангаагүй" үл хөдлөх эд хөрөнгөд Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т заасан эрх бүхий этгээдээс нэмэгдүүлж тогтоосон хувь хэмжээгээр татвар ногдуулна.

3.2. "Шаардлага хангаагүй" үл хөдлөх эд хөрөнгийг албан татвараас чөлөөлөх, хөнгөлөх, ногдуулах, төсөвт төлөхтэй холбогдох харилцаанд Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийг баримтална.

Дөрөв. Хяналт тавих

4.1. Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь энэ журмын 2.2, 2.3, 2.4-д заасан мэдээллийн үнэн зөв байдалд хяналт тавьж, хэрэгжилтийг ханган ажиллана.

4.2. Татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь энэ журмын 2.5-д заасан мэдээлэлд үндэслэн албан татвар ногдуулалт, төлөлтөд хяналт тавьж, хэрэгжилтийг ханган ажиллана.

